



ХЭНТИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
05 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 09

Чингис хот

“Ирээдүйн эзэд” хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын “Ирээдүйн эзэд” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг аймгийн хөгжлийн жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, үр дүнг тооцон жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Аюурбунь)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгэм, хүний хөгжлийн хороо (Ж.Равжих)-нд үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦОГТ-ОРШИХ



Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 07 дүгээр сарын 11 өдрийн 02 дугаар
хуралдааны 02 дугаар тогтоолын хавсралт

“ИРЭЭДҮЙН ЭЗЭД” ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын төрөөс гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих чиглэлээр бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомжуудыг боловсруулан хэрэгжүүлэх, шинэчлэх ажилд онцгой анхаарч байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр “Засгийн газрын бүтцийн тухай” хууль баталж, **Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам** байгуулсан нь гэр бүлийн асуудлыг дагнан хариуцсан төрийн яамны бүтэц бий болсон анхны тохиолдол болоод байна.

Манай Улсын хувьд гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч, найман гэр бүлийн нэг нь хамтран амьдрагчид болж, залуус гэр бүлийн амьдралд хангалттай бэлтгэгдээгүйгээс гэр бүл салах, гэр бүл салсны дараа эцэг эх нь үр хүүхдэдээ тавих анхаарал халамж дутмаг, хүүхдээ авч үлдсэн гурван хүн тутмын хоёрт нь хариуцлага ачаалал нэмэгдэж, хүүхдийн сурлага хүмүүжил муудах, гэр бүлийн хүчирхийлэл ихсэх, гэр бүлийн үүрэг хариуцлага суларч байгаа зэрэг нь судалгаагаар нотлогдож байна.¹

Хосууд гэр бүлийн харилцааны зөрчлөө хэрхэн зөв шийдвэрлэх, хүүхдээ яаж зөв хүмүүжүүлэх зэрэг олон асуудлаар мэдлэг дутмаг байна. Сүүлийн 10 жилд гэрлэлтээ цуцлуулагчдын тоо тогтмол өсөж байна. Гэр бүлээ цуцлуулсан өрхийн 70.0 хувь нь 0-15 насны, дунджаар 2-3 хүүхэдтэй байна².

Хэнтий аймгийн хувьд нь 18 сум, 5 тосгонтой. Нийт 78877 хүн амтай, 28687 хүүхэдтэй буюу хүн амын 36,3 хувийг хүүхэд эзэлдэг. Нийт өрхийн тоо 25856, өрх толгойлсон эцэг эх 1698 байгаагаас эмэгтэй өрх толгойлсон өрх 1491 байна. Сүүлийн 5 жилийн дунджаар жилдээ 315 гэр бүл гэрлэлтээ батлуулж, 69 гэр бүл цуцлалт хийлгэсэн байна.

2024 онд Гэр бүлийн хүчирхийллийн 343 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, үүнээс гэмт хэрэг 2, зөрчил 341 бүртгэгдсэн. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гэмт хэргийн тоо буурч, зөрчлийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Өнгөрөгч онд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7,7 хувиар, хүүхэд хохирсон гэмт хэрэг 26,3 хувиар өссөн байна. Үүнээс зонхилон тохиолдож буй гэмт хэрэгт хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, хүчиндэх, хулгайлах, хөдөлгөөний аюулгүй байдлын болон тээврийн хэрэгсэл ашиглах журмын эсрэг зэрэг гэмт хэрэг тус тус үйлдэгдсэн байна.

2024 онд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас Хүүхдийн эрхийн зөрчлийн 122 дуудлагад хамаарах 271 хүүхдэд, 1231 удаагийн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн байна. Хүүхдийн эрхийн зөрчлийн 80 орчим хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгдэж, зонхилон тохиолдож буй хэлбэр нь үл хайхрах болон сэтгэл санааны дарамт байгаа бөгөөд

¹ Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал-суурь судалгаа. НҮБХАС, ОУУБИС, ХНХЯ, ШУА. 2010, 2018он

² Статистикийн газрын мэдээлэл. 2023

өсвөр насны охид бэлгийн хүчирхийлэлд өртөх нь буурахгүй байгаа нь гэр бүлийн орчинд хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, анхаарал хандуулах шаардлагатай байгааг илэрхийлж байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Монгол Улсын төрөөс гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн харилцаанд оролцох эрхийг хангах, зөв хүмүүжил төлөвшлийг дэмжиж, хүүхэд хамгааллын тогтолцоог салбар дундын оролцоотойгоор бэхжүүлсэн хүүхдэд ээлтэй аймаг болно.

ГУРАВ.ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2025-2030 он хүртэл 5 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

“Ирээдүйн эзэд” хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийг Хэнтий аймгийн хэмжээнд хэрэгжүүлнэ.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Хөтөлбөрийн хүрээнд үндсэн 10 зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

ЗОРИЛТ 1. СУДАЛГААНД СУУРИЛСАН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛНА.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлт хандлагыг тодорхой хугацааны давтамжтайгаар судалж үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгаж ажиллах,
2. Мэргэжлийн байгууллагатай харилцан туршлага солилцох, гэр бүл, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр судалгаа, ном гарын авлага боловсруулах олон нийтийн хүртээл болгох,
3. Хүүхэд, гэр бүлийн статистик мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад салбар дундын уялдааг хангаж, мэдээллийн сангийн чанарыг сайжруулах, дүн шинжилгээ хийх, гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх,
4. Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний чанар хүртээмж, иргэдийн ойлголт хандлагыг тодорхойлох судалгааг тодорхой давтамжтай зохион байгуулах

Хүрэх үр дүн

1. Судалгаанд суурилсан хэрэгцээг хангах оновчтой үйл ажиллагаа хэрэгжинэ.
2. Гэр бүл, хүүхдийн асуудлаар шаардлагатай суурь судалгаа, мэдээлэл, бодлого, зөвлөмж бий болно.
3. Хүүхэд, гэр бүлийн статистик мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад салбар дундын уялдаа сайжирна



ЗОРИЛТ 2. ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР ГЭР БҮЛ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ НИЙГМИЙН ОРЧИН БҮРДҮҮЛНЭ.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг тухайлан бэлтгэх,
2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтэс, бусад байгууллагын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн сургах, чиг үүргийг жигд тодорхой болгох,
3. Гэр бүл, хүүхдэд үйлчилгээ үзүүлэх асуудлаар бусад орны болон аймгийн мэргэжлийн байгууллага, хүмүүстэй харилцан туршлага солилцож, үйл ажиллагааны хүрээгээ өргөжүүлэх, хамтрах,
4. Олон улсын болон хөгжлийн байгууллага, агентлагийн гэр бүл, хүүхдийн хөгжилд зориулж байгаа дэмжлэг, үйл ажиллагааг хөтөлбөртэй уялдуулах,
5. Гэр бүлийн өдөр, гэр бүл, хүүхдийн амралт, чөлөөт цагийн газруудыг бий болгох, гэр бүлд чиглэсэн дэмжлэг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийг урамшуулах
6. Орон нутгийн Хамтарсан баг, бүх шатны Засаг даргын дэргэдэх Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, гишүүдийг хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сургах

Хүрэх үр дүн

1. Гэр бүл хүүхдийн чиглэлээр ажилладаг төр болон төрийн бус байгууллагуудын хүний нөөц, чадамж дээшилж, түншлэл бий болно.
2. Гэр бүл, хүүхдэд ээлтэй байгууллага нэмэгдэж, нийгмийн орчин сайжирна.
3. Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөц сайжирна.

ЗОРИЛТ 3. ГЭР БҮЛД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨГӨӨ, СУРГАЛТЫН АЖЛЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЗАМААР ГЭР БҮЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАНА.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Зорилтот бүлгүүдэд (Залуу, дунд, ахмад насны гэр бүл, өсвөр үе, бусад) зориулсан гэр бүлийн боловсролын сургалтын агуулга, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх,
2. Гэр бүлийн боловсрол олгох сургалт, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлэх
3. Нийгэмд эерэг нөлөө үзүүлж байгаа гэр бүлүүдийг урамшуулах, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх нөлөөллийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах,
4. Бүсийн "Гэр бүлийн хөгжлийн төв" байгуулах,

Хүрэх үр дүн

1. Хүний нас зүй, гэр бүлийн амьдралын мөчлөгийн дагуу гэр бүлийн боловсрол олгох сургалтууд хийгдэнэ.
2. Гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагаа, сургалт эрчимжсэнээр иргэдийн мэдлэг ойлголт нэмэгдэнэ.



3. Иргэд хаана амьдарч байгаагаасаа үл хамааран гэр бүлийн тулгамдсан асуудлаар мэргэжлийн үйлчилгээ авах боломж бүрдэнэ.
4. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал сайжирна.
5. Сумдад гэр бүлийн хөгжлийн үйлчилгээг явуулах жишиг төвийн загвар бий болно.

ЗОРИЛТ 4. ЭЦЭГ, ЭХИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ БЭХЖҮҮЛНЭ.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Эцэг, эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хүүхдийг сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх гэр бүлийн орчныг сайжруулахад чиглэсэн эцэг, эхийн боловсролын сургалтыг эрчимжүүлэх,
2. Өрхийн аюулгүй, эрсдэлгүй орчныг бий болгоход нөлөөлөх, зөвлөмжийг түгээх,
3. Хүүхдийг чанартай хоол хүнс, шаардлагатай амин дэмээр дутаахгүй байх, хүүхдийн бие махбод, сэтгэл зүйн хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлэх уриалгыг түгээх,
4. Эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтэд хүүхдийг асрах, эерэг аргаар хүмүүжүүлэх мэдлэг, хандлага төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг сургалтад хамруулах,
5. Хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч нарын хариуцлагыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг өрнүүлж, санамж, сэрэмжлүүлэг түгээх,
6. Үр хүүхдээ тэвчишгүй, хүнд хөдөлмөр эрхлүүлэхгүй байх, гэмт хэрэг зөрчлийн оролцогч болохоос сэргийлэх, нийгмийн оролцоот иргэн болгон төлөвшүүлэхэд шаардлагатай ур чадварыг эцэг эхчүүдэд олгох

Хүрэх үр дүн

1. Гэр бүл дэх хүүхдийн үндсэн эрх ашиг хангагдах, эцэг, эхийн үүрэг хариуцлага, боловсролыг нэмэгдүүлэх, хүүхдийг гэр бүлийн орчинд хүчирхийлэх явдлыг таслан зогсоох үйл ажиллагаанууд нэмэгдэнэ.
2. Хүүхэд, өсвөр үеийнхнийг нийгмийн хариуцлагатай гишүүн болгон хүмүүжүүлэх ажилд эцэг эх, насанд хүрсэн гишүүдийн үүрэг, оролцоо нэмэгдэж, эцэг, эхийн хариуцлага сайжирна.

ЗОРИЛТ 5. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХАД САЛБАР ДУНДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛНЭ.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Гэр бүл, хүүхдийн эрх ашигтай холбоотой үндэсний бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг салбар бүрд сайжруулах, салбар бүрийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх
2. Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийг тухайлан сурталчлан таниулах,
3. Бүх шатны байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж хүүхэд хамгааллын бодлогыг /хүүхэд, гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлого/ хэрэгжүүлэх.



хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд байгууллага аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх,

4. Хүүхэд төвтэй гэр бүлийн халуун дулаан, амар тайван харилцааг бэхжүүлэх, нийтийг хамарсан нөлөөллийн ажил, хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хамгаалах асуудалд салбар бүрийн оролцоог нэмэгдүүлэх,
5. Хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх,
6. Хүүхэд нийгмийн бүх орчинд хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлд өртөөж болзошгүй, эрсдэлд өртсөн хүүхэд, гэр бүлд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх,
7. Гамшгийн үед хүүхдийн эрхийг хамгаалах, тэдэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх, сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагад гамшгаас хамгаалах дадлага, сургуулилалтыг тогтмолжуулах,
8. Гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, сэжигтэн, мөрдөн шалгагдаж байгаа, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, шүүхээр шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах,


Хүрэх үр дүн

1. Хүүхдийн эрүүл, аюулгүй өсөж, хөгжих орчныг бүрдүүлэхэд салбар дундын оролцоо сайжирна.
2. Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах боломж нэмэгдэнэ.
3. Гэр бүлийн эерэг харилцаа, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчин бүрдэхэд аж ахуйн нэгж байгууллага, хамт олны оролцоо нэмэгдэнэ.

ЗОРИЛТ 6. ХҮҮХЭД БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, ХҮҮХДИЙН АВЬЯАС, ЧАДВАРЫГ НЭЭН ХӨГЖҮҮЛЭХЭД САЛБАР БҮРИЙН ОРОЛЦООГ ХАНГАНА.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд төрийн болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, эцэг эх, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх,
2. Хүүхдээс гарсан саналыг сонсох, шийдвэр гаргах түвшинд уламжлах, шийдвэрлүүлэх,
3. Бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих чиглэлээр бий болсон сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, эцэг эхийн чадавхыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээлэл, цахим сүлжээ ашиглах,
4. Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэн хөгжүүлэх асуудалд салбар бүрийн оролцоог нэмэгдүүлэх,
5. Хүүхдэд байгаль орчноо хайрлах, үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх, суралцахад чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн музей, номын сан, хэвлэл мэдээлэл, соёл, урлагийн байгууллагуудаар дамжуулах хэрэгжүүлэх,



6. Хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цагийн төв байгуулах, тохижуулах, засварлах талаар санаачилга гаргаж байгаа иргэн, байгууллагыг дэмжих, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх заалтыг хэрэгжилтийг хангуулахад орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах
7. Хүүхдэд чиглэсэн хөгжлийн хувилбарт үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, чанар, хүртээмжийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх, хичээлээс гадуурх сонгон, секц, дугуйлангийн хүртээмж, үнэ төлбөрийн байдалд үнэлгээ хийх,
8. Хүүхдийн дунд явагдах хөгжлийн арга хэмжээнд хүүхдийн жигд оролцоог хангах, оюун ухаан, урлаг, спортын олон төрлийн уралдаан, тэмцээн зохион байгуулах,
9. Урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан, хүүхдийн санаачилсан шинэ бүтээлийг дэмжих, урамшуулах,
10. Хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахуун, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн контентыг дэмжих, хүүхдэд зориулсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэх,

Хүрэх үр дүн

1. Хүүхдэд чиглэсэн хөгжлийн үйлчилгээний хүртээмж сайжирна.
2. Хүүхдийн авьяас чадварыг нээж, хөгжүүлэх үйл ажиллагаанд ахиц дэвшил гарна.
3. Хүүхдэд үзүүлэх боловсрол, нийгмийн болон хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.

ЗОРИЛТ 7. ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ХҮҮХДИЙН СЭРГИЙЛЖ БОЛОХ ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛНА.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Товлолт болон сайн дурын дархлаажуулалтад хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх,
2. Хүүхэд бүрийг бодисын солилцооны эмгэг, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд тогтмол хугацаанд хамруулах,
3. Алслагдсан болон орлого багатай өрхийн хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч, нэн шаардлагатай амин дэмээр хангах, амин дэм түгээх явцад хоол тэжээлийн зөвлөгөө өгөх ажлыг хавсран явуулах,
4. Хүүхдийн шүдний цоорол, өвчлөлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн шүдний эрүүл мэндийн мэдээлэл, сургалтыг өргөжүүлэх,
5. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол, үдийн цай хөтөлбөр, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавих ажлыг эцэг, эхийн оролцоотой зохион байгуулах,
6. Хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээг сургууль, цэцэрлэгийн орчинд хориглох,
7. Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх,



8. Өсвөр насныхны нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг аймаг, сумын түвшинд сайжруулах,
9. Сургууль, цэцэрлэг, хүүхдийн эмнэлэг болон хүүхдийн сургалт, үйлчилгээний байгууллагын эрүүл ахуйн стандартын шаардлагыг тогтоож мөрдүүлэх,

Хүрэх үр дүн

1. Хүүхдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
2. Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйл явцад ахиц дэвшил гарна.

ЗОРИЛТ 8. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ХҮЧИРХИЙЛЛИЙГ БУУРУУЛНА.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Гэр бүлийн хүчирхийллийн суурь судалгааг тодорхой давтамжтайгаар хийж, судалгаанд суурилсан төлөвлөлтийг хийх,
2. Гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх,
3. Хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчид сэтгэц заслын үйлчилгээг үр дүнтэй хүргэх боломжийг бүрдүүлэх ба ялангуяа эрэгтэйчүүдийн зан үйл, сэтгэл зүйн онцлогт тохирсон модуль сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх,
4. Эмэгтэйчүүд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдийг хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйлээс өөрийгөө хамгаалах боломжийг нэмэгдүүлж, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, хяналтын тогтолцоог бүхий л түвшинд сайжруулах,
5. Нэг цэгийн үйлчилгээний төвийг стандартын дагуу ажиллах нөхцөл боломжоор хангах,

Хүрэх үр дүн

1. Иргэд, хүүхэд, өсвөр үе, залуусын гэр бүл, хүүхдийн эрх зүйн мэдлэг мэдээлэл нэмэгдэж, хуулийн хэрэгжилт сайжирна.
2. Гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээ нэмэгдэж, гэр бүлийн асуудлаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчил буурч, гэр бүлийн нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлага дээшилнэ.

ЗОРИЛТ 9. ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ГЭР БҮЛ САЛАЛТЫГ БУУРУУЛНА.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Залуу эцэг, эхчүүдэд зориулан хүүхдээ эрүүл өсгөн бойжуулах, хөгжлийг нь дэмжих, анхны жилүүдийн хямралыг даван туулах, ойлголцох, зөрчлийг шийдвэрлэхэд туслах сургалт зөвлөгөөнд зайлшгүй хамрагддаг нөхцөлийг бүрдүүлэх,
2. Залуу гэр бүлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр байр сууцтай болох асуудлыг ажил олгогчид болон аж ахуйн нэгжүүдтэй хамтран шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх,
3. Залуучуудын ажлын байр нэмэгдүүлж гэр бүлийн санхүүгийн чадавхыг дээшлүүлэх, эдийн засгийн чадавхгүй залуу гэр бүлд дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх,

Хүрэх үр дүн

1. Залуу гэр бүлийн амьдралыг бэхжүүлэх бодлого хэрэгжүүлснээр гэр бүлийн сөрөг асуудлууд, салалт буурна.
2. Ажил олгогчдын хувьд ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөхөөс гадна залуучууд урт удаан тогтвортой ажилтай байх нөхцөл бүрдэнэ.
3. Гэр бүл, хүүхдийн хувьд эрсдэлээс хамгаалагдах боломж нэмэгдэнэ.

ЗОРИЛТ 10. ХӨДӨӨГИЙН ГЭР БҮЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРТЭХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Хөдөөгийн гэр бүлд хөгжлийн үйлчилгээг цогцоор хүргэх боломжийг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын дадалд суралцуулах,
2. Гэр бүлийг хөгжүүлэх, тэднийг шаардлагатай мэдээллээр хангах, олон нийтийн ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх, үйлчилгээг хүргэх оновчтой арга, хэлбэрийг бий болгох,

Хүрэх үр дүн

1. Хөдөөгийн гэр бүлд үзүүлэх үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.
2. Хөдөөгийн гэр бүлүүд шаардлагатай мэдээлэл авах боломж бүрдэнэ.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

6.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

- 6.1.1 Хөтөлбөрийн удирдах дээд байгууллага нь Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар байна.
- 6.1.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамжаар томилж, ерөнхий зохион байгуулалтыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хариуцна.
- 6.1.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахдаа орон нутгийн нийгэм эдийн засгийн бодлого, хүний хөгжлийн асуудлаарх бусад хөтөлбөртэй уялдуулан төлөвлөж, зохицуулах үйл ажиллагаа явуулна.
- 6.1.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах бүрэлдэхүүн боловсруулна.
- 6.1.5 Хөтөлбөрийн холбогдох асуудлаар байгууллага, аж ахуйн нэгж, төр, төрийн бус байгууллага, иргэний нийгэм, олон нийтийг удирдамж, чиглэл, шаардлагатай мэдээллээр хангаж, тэдний санал бодлыг тусган үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.
- 6.1.6 Иргэний нийгмийн байгууллагаас ирүүлсэн санал, санаачилгыг судлан, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх болон хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллаж болно.

6.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоо, тайлагналт

- 6.2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад салбар дундын оролцоог хангаж, хэрэгжилтийн үйл явцыг хагас жил тутам хэлэлцүүлгээр дамжуулан хянаж, олон нийтэд мэдээлнэ.



- 6.2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг салбар бүрээр төсөвт тусгасан байна.
- 6.2.3 “Ирээдүйн эзэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг сум бүр боловсруулан сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнээр баталгаажуулж, аймгийн Засаг даргын удирдлага дор хэрэгжүүлнэ.
- 6.2.4 Хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан тайланг хариуцагч байгууллага бүр жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт ирүүлнэ. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь тайланг нэгтгэж, нэгдсэн тайланг дараа оны АИТХ-ын эхний хуралдаанд танилцуулна.
- 6.2.5 Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил тутам аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийг гаргах, сайн хэрэгжүүлсэн салбар, идэвх зүтгэлтэй ажилласан байгууллага, хувь хүнийг олон нийтэд мэдээлэн урамшуулна.
- 6.2.6 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцаас хамааран зорилт, арга хэмжээнд өөрчлөлт оруулах тохиолдолд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах бүрэлдэхүүнд хандаж өөрчлөлтийг тусгуулна.

6.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах төрийн чиг үүрэг бүхий байгууллагууд

- ✓ Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- ✓ Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар
- ✓ Сумдын Засаг даргын тамгын газар
- ✓ Цагдаагийн газар
- ✓ Боловсролын газар
- ✓ Эрүүл мэндийн газар
- ✓ Онцгой байдлын газар
- ✓ Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар
- ✓ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
- ✓ Татварын газар
- ✓ Улсын бүртгэлийн хэлтэс
- ✓ Биеийн тамир, спортын газар
- ✓ Хүнс хөдөө аж ахуйн газар
- ✓ Политехникийн коллеж
- ✓ Ерөнхий боловсролын сургуулиуд
- ✓ Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
- ✓ Насан туршийн суралцахуйн төв
- ✓ Хэнтий орон сууц ОНӨААТҮГ



6.4 Хөтөлбөрийн иргэний нийгмийн байгууллагын оролцоо

6.4.1 Гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын хэрэгцээнд тохирсон үйл ажиллагаа явуулах эрмэлзэл, манлайллыг хөгжүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулах

6.4.2 Хөтөлбөрийн хэрэгжилтэд өрх, гэр бүлийн оролцоог хангах, хэрэгцээ, шаардлагыг төрийн байгууллагад хүргэх

6.4.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнд хяналт тавих чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах

6.4.4 Хөтөлбөрийн холбогдох асуудлаар төсөл боловсруулан төр, олон улсын байгууллага, хандивлагчдад хандах, хөрөнгө, нөөцийг дайчлах

6.4.5 Гэр бүлийн эрх ашигтай холбоотой бүхий л асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тэдний нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн хэмжээний хурал зөвлөгөөн зохион байгуулах

6.4.6 Үндэсний хэмжээний болон олон улсын хурал, зөвлөгөөн, сургалтад зохих төлөөллийг оролцуулж байх

6.5 Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо

6.5.1 Гэр бүлийн хөгжлийн чиглэлээр зохион байгуулж буй зарим арга хэмжээг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх, хөрөнгө дайчлах, нэмэгдүүлэх арга хэмжээ авах

6.5.2 Олон нийтийг хамарсан компанит ажил зохион байгуулах талаар бусад байгууллага, залуучуудтай хамтран ажиллах

6.5.3 Гэр бүлийн хөгжүүлэх үйлчилгээг байгууллагынхаа дэргэд нээн ажиллуулах, тэдний өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар манлайлах

6.5.4 Ажиллагчдынхаа гэр бүлийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр жил бүр тодорхой хөрөнгийг тусган хэрэгжүүлэх;

6.5.5 Хүүхдийн цэцэрлэг, ясли, зуслан, сувилал ажиллуулах, туслах аж ахуй хөгжүүлэх, орон сууц барих зэрэг арга хэмжээнд зохих хөрөнгө зарцуулах санаачилга гаргах

6.5.6 Олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой, зорилтот өрхөд дэмжлэг үзүүлэх

6.6 Гэр бүл, олон нийтийн оролцоо

6.6.1 Байгууллага, аж ахуйн нэгжээс зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох, мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэх, бусдад үлгэр дуурайл болж байх

6.6.2 Нийгэмд сөргөөр нөлөөлж буй зар сурталчилгаа, зуучлал, зохисгүй үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэхэд оролцож байх

6.6.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, төлөөллийн байгууллагатайгаа хамтран ажиллах

6.7 Хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо

6.7.1 Хөтөлбөрийн хэрэгжилт, арга хэмжээг сурталчлах, ил тод байдлыг хангах

6.7.2 Гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийтлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, гэр бүлд эерэг нөлөөлөл үзүүлэх, боловсрол олгоход чиглэсэн, өдөр тутмын хэрэгцээт



мэдээллийг хүргэх нэвтрүүлэг, сурталчилгаа, нийтлэлийг хөгжүүлэх

6.7.3 Олон нийтийн хэрэгцээ, дуу хоолой, санал бодлыг хэвлэл мэдээллээр дамжуулан холбогдох байгууллагад хүргэх

6.7.4 Гэр бүлийн асуудлаарх Олон улсын хэмжээний хурал зөвлөгөөн, бодлого шийдвэрийг сурталчлах, түүний хэрэгжилтийн талаарх иргэдийн санал бодлыг тусгах

6.8 Хөтөлбөрийн олон улсын хамтын ажиллагаа, түншлэл

6.8.1 “Ирээдүйн эзэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын болон гадаадын байгууллагаас дэмжлэг авах чиглэлээр хамтран ажиллана.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

7.1 Улсын болон орон нутгийн төсөв

7.2 Гадаад, дотоодын байгууллагын зээл, тусламж, хандивын хөрөнгө

7.3 Иргэн, хуулийн этгээдийн гэр бүл, хүүхдийг дэмжихэд зориулан олгосон зээл, тусламж, хандивын хөрөнгө

7.4 Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж;

7.5 Бусад

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

8.1 Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрагдаж чадавхажсан мэргэжилтэн болон хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн тоо,

8.2 Хүүхэд хамгааллын бодлого баталж, мөрдсөн байгууллага, аж ахуй нэгжийн тоо

8.3 Гэр бүлийн үнэ цэнэ, сайн сайхан байдлыг сурталчлах, гэр бүлийн боловсрол олгох, хууль сурталчлах чиглэлээр хийгдсэн нэвтрүүлэг, гарын авлагын тоо,

8.4 Гэр бүл, хүүхдийн асуудлаар хийгдсэн суурь судалгааны тоо,

8.5 Орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээрх лекц, сургалтын тоо, хамрагдсан иргэд,

8.6 Шинээр бий болсон гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн тоо

8.7 Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжөөр хангасан хөрөнгийн хэмжээ,

8.8 Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн өсөлт, бууралтын хувь

8.9 Гэр бүлийн зөвлөгөө авсан хүний тоо,


8.10 Гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон нийтийн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо

8.11 Гэрлэлтийн гэрчилгээ авахын өмнө сургалтад хамрагдсан хосын тоо

8.12 Хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн нийт хүүхдэд эзлэх хувь

8.13 Зохион байгуулсан уралдаан тэмцээний тоо, хамрагдсан хүүхдийн тоо

8.13 Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн арга хэмжээний



тоо, хамрагдсан иргэдийн тоо

8.14 Хөтөлбөрийн хүрээнд шилдэг, байгууллага, аж ахуй нэгж, иргэн, хүүхдийг, шалгаруулж дэмжлэг үзүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ,

8.15 Олон улсын болон хөгжлийн байгууллага, ТББ, агентлагийн хүүхэд, гэр бүлийн хөгжилд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, /мөнгөн дүн/

8.16 Сум, орон нутгийн гэр бүлд үзүүлсэн явуулын үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо

8.17 Хүүхдийн товлолт болон сайн дурын дархлаажуулалтад хамрагдалтын хувь

8.18 Эрт илрүүлэгт хамрагдалтын хувь /хүүхдийн/

8.19 Шүдний цоорол өвчнийг бууруулахад чиглэсэн сургалт, арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо

8.20 Өсвөр насныханд зориулсан нөхөн үржихүй болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамрагдалтын хувь

8.21 Хөнгөлөлттэй нөхцөлөөр гэр, орон байрны дэмжлэг авсан залуу гэр бүлийн тоо

8.22 Хөдөөгийн гэр бүлд үзүүлсэн явуулын үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

9.1. Хүүхэд бүр гэр бүлдээ эцэг эхийн хайр халамжид эрүүл энх өсөж, хүмүүжиж төлөвших боломж бүрдэж, эцэг эх, асран хамгаалагч болон нийгэм, иргэдийн хүүхдэд тавих анхаарал, халамж, үүрэг хариуцлага нэмэгдэнэ.

9.2. Хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлсэн, хүүхдэд ээлтэй орчин бүрдсэн байна.

9.3. Гэр бүлд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөө, гэр бүлийн боловсролын сургалт нөлөөллийн ажил өргөжиж гэр бүлийн тогтвортой байдал, үнэ цэнэ дээшилсэн байна.

9.4. Гэр бүл, хүүхдийн талаарх аймгийн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт сайжирсан байна.

---oOo---

